



ᠬᠥᠪᠰᠭᠦᠭᠡᠯ ᠤᠰ ᠰᠤᠪᠠᠭ ᠬᠡᠬᠡ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠡᠰᠢᠷ



# “ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК

2024 ОН





# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөвсгөл аймаг нь 1931 онд байгуулагдсан. Засаг захиргааны нэгжийн хувьд 23 сум 1 тосгон 129 багтай. Хойд талаараа ОХУ, баруун, зүүн болон өмнө талаараа Завхан, Булган, Архангай аймагтай хиллэдэг. Нийт газар нутгийн хэмжээ 100,6 мянган км<sup>2</sup>, газар нутгийн хэмжээгээрээ улсдаа 6 дахь том аймаг юм. Газар нутгийн 41,8 хувийг ой, 3.6 хувийг ус, 54.5 хувийг хадлан, бэлчээрийн талбай эзэлдэг.



Нутаг дэвсгэр - **100,6** мян км<sup>2</sup>

Засаг захиргааны нэгж  
**23** сум, **1** тосгон, **129** багтай

Хүн ам - **137,0** мян

Ойн сан бүхий газар - **4005,4** мян

Малын тоо – **6,2** сая

Тусгай хамгаалалтын газар  
нутгийн хэмжээ – **53,4** мян км<sup>2</sup>




## ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ /ЦААШДЫН ЗОРИЛТ/

Хөвсгөл аймгийн Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг хөдөө аж ахуйн салбар тэр дундаа мал аж ахуй салбар юм. Цаашид мал аж ахуйн салбараас гадна аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Аймгийн 23 сум, 1 тосгон 129 багийн 19543 малчин өрх 6,2 сая толгой мал маллаж байна.

Жилд дунджаар 1.8 сая төл мал хүлээн авч, 1,2-1,5 сая толгой малыг зах зээлийн эргэлтэд оруулдаг. Мал аж ахуйгаас **360,0 тэрбум** орчим төгрөгийн орлого олж байгаа тооцоо байдаг.





# “ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ᠬᠥᠪᠰᠭᠦᠯ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ





ᠬᠥᠪᠰᠦᠭᠡᠯ ᠠᠶᠢᠮᠠᠭ  
ᠵᠢᠰᠢᠭ ᠳᠠᠷᠲᠦᠨ ᠲᠠᠮᠭᠦᠨ ᠭᠦᠰᠠᠷ  
ᠬᠥᠪᠰᠦᠭᠡᠯ ᠤᠰ ᠰᠤᠪᠠᠭ ХХҮ

# 2599 айл өрхийг цэвэр усаар хангаж, бохир усыг татан зайлуулах үйлчилгээг үзүүлж байна.



317

Ахуйн нэгжийн байгууллага



57

Орон сууц



567

Хувийн сууц /хаус/





# Гэр хорооллын 40 мянга гаруй айл өрхийг ундны цэвэр усаар хангаж ажиллаж байна

АВТОМАШИН -4

Зөөврийн ус хангамжийн  
автомашин



УС ТҮГЭЭХ ЦЭГ -26

Зөөврийн ус түгээх цэг



ГҮНИЙ ЭХ  
ҮҮСВЭРТЭЙ УС  
ТҮГЭЭХ -3


24 цагийн тасралтгүй үйл  
ажиллагаатай 23 ухаалаг ус  
түгээх цэгээр




ᠬᠥᠪᠰᠦᠭᠡᠯ ᠠᠶᠢᠮᠠᠭ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠡᠰᠡᠷ

## ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАН АЖИЛЛАЖ БАЙНА

5 нам даралтын зуухнаас 2 сургууль, 4 цэцэрлэг,  
1 үйлдвэрийн газар нийт 16 төсөвт болон аж ахуйн нэгж газар,  
**114** айл өрхийг дулааны эрчим хүчээр ханган ажиллаж байна.

 [ussuvag.khs.gov.mn](mailto:ussuvag.khs.gov.mn)

 [Хөвсгөл Ус Суваг](#)





## Бүтэц, зохион байгуулалтын хувьд:



1. Захиргаа аж ахуйн салбар

2. Усан хангамж, цэвэрлэх байгууламжийн салбар

3. Дулаан хангамж, нийтийн халуун усны салбар

4. Цахилгаан автоматжуулалт, тээвэр үйлчилгээний салбар

Нийт үндсэн **145**, гэрээт **9** ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

№	Боловсрол	Тоо	Эзлэх хувь
1	Дээд	52	36.9%
2	Тусгай дунд	32	19.8%
3	Бүрэн дунд	60	42.6%
4	Бүрэн бус дунд	1	0.7 %
НИЙТ		145	100%

№	Мэргэжил	Тоо	Эзлэх хувь
1	Мэргэжилтэй	84	56.73%
2	Мэргэжилгүй	61	43.27%
НИЙТ		145	100%

№	Хүйс	Тоо	Эзлэх хувь
1	Эрэгтэй	83	57%
2	Эмэгтэй	60	43%
НИЙТ		145	100%





## Орон нутгийн дэмжлэг

Аймаг орон нутгийн зүгээс НАА-н байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ирсэн ба гэр хорооллын цэвэр ус хангамжийн үйлчилгээний алдагдлыг бууруулах зорилгоор 308,8 сая төгрөг, шинээр байгуулагдсан цэвэрлэх байгууламжийн ашиглалтын зардалд 205 сая төгрөг нийтдээ 513,7 сая төгрөгийн татаасыг олгож байна.





Нийтийн аж ахуйн салбар 2023 онд "Усны ухаалаг тоолуур хэрэглээндээ нэвтрүүлэх" жил болгон зарласантай холбогдуулан өөрийн хөрөнгөөр цэвэр усны ухаалаг тоолуурыг хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна.



Нийтийн аж ахуйн салбар 2023 онд "Усны ухаалаг тоолуур хэрэглээндээ нэвтрүүлэх" жил болгон зарласантай холбогдуулан өөрийн хөрөнгөөр цэвэр усны ухаалаг тоолуурыг хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна.



## 2023 онд хийж гүйцэтгэсэн томоохон ажлуудын ТОВЧОО:



- Ундны усны хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд ухаалаг худгийн тоог нэмэгдүүлэв.
- Олон жилийн насжилттай ус түгээх байруудад их засварын ажлыг шат дараалалтайгаар хийж ажилласан.
- Ус түгээх байрны ус нөөцлөх савыг сольж шинэчлэх ажил хийгдсэн





“ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН ДОТООД ХЯНАЛТЫН  
ЛАБОРАТОРИ 2 ҮНДСЭН ЧИГЛЭЛЭЭР ХЯНАЛТ ТАВИН  
АЖИЛЛАЖ БАЙНА

Хүн амын  
ундны усны чанар

Хэрэглээнээс гарсан бохир ус  
болон цэвэршүүлсэн бохир  
усны чанар





ᠬᠥᠪᠰᠭᠡᠯ ᠠᠶᠢᠮᠠᠭ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠷᠠᠮ

## “ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН ХҮН АМЫН УНДНЫ УСНЫ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ



Азийн хөгжлийн банк болон орон нутгийн санхүүжилтээр “УНДНЫ УС ЗӨӨЛРҮҮЛЭХ” тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах, ашиглалтад оруулах ажил хийгдэж байна.





## БҮРЭН БИОЛОГИ ЦЭВЭРЛЭГЭЭТЭЙ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



2021 оны 07-р сард Азийн Хөгжлийн Банкны зээлийн хөрөнгөөр хоногт 3000м<sup>3</sup> ахуйн бохир ус хүлээн авах Бүрэн биологи цэвэрлэгээтэй 19 инженер, техникч, лабораторийн ажилчидтай цэвэрлэх байгууламж ашиглалтад орсон.

Цэвэрлэх байгууламжийн бохир усны дотоод хяналтын лаборатори нь өдөрт ирж байгаа бохир усны оролтын бохирдолт, гаралтын цэвэршилтийн түвшинд хяналтыг тавин ажилладаг.

Манай лаборатори нь бохир усанд хяналтыг тавихдаа Монгол улсад мөрдөгдөж байгаа **MNS 5582:2005**, **MNS 6561:2015**, **MNS 4943:2015** стандартуудад заасан хими, физикийн–11, гидробиологийн–5, үзүүлэлтээр шинжилгээг хийдэг. Мөн хөндлөнгийн хяналтын шинжилгээг тогтмол хийлгэж харьцуулсан үзүүлэлтүүдийг гарган ажиллаж байна.



ᠪᠦᠷᠦᠨ ᠪᠢᠣᠯᠣᠭᠢ ᠴᠡᠪᠦᠷᠯᠡᠭᠡᠡᠲᠡᠢ ᠴᠡᠪᠦᠷᠯᠡᠬᠡ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠠᠮᠵᠢᠨ ᠲᠣᠪᠴᠢ ᠲᠠᠨᠢᠯᠴᠤᠭᠤᠯᠭ᠋ᠠ



Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Цэвэрлэх байгууламжийн лабораторид 9 нэр төрлийн шил сав, 13 нэр төрлийн бодис, 7 нэр төрлийн багаж тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Дутагдалтай байсан багаж тоног төхөөрөмжтэй болсоноор засвар үйлчилгээ хийхэд ажилчдын бүтээмж сайжирч, бохир усны лабораторид шил сав, бодис ирсэнээр шинжилгээ хийхэд хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахад дөхөм болж байна.





## Хүлэмж

Хүлэмжинд үрсэлгээгээр суулгасан Чацаргана, Голтбор, Шар хуайс зэрэг мод, улаан лооль, өргөст хэмх, улаан, ногоон чинжүү зэрэг нарийн ногоо тариалсан нь ургалт сайтай байна.

Мөн гадна ил талбайд төмс, сонгино тариалалтын хугацаанаас хойно тариалсан ч ургац сайн гарсан.








ᠬᠥᠪᠰᠭᠡᠯ ᠠᠶᠢᠮᠠᠭ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠦᠵᠢᠷ



Автоматжуулалт, хяналт удирдлагын SCADA системийг нэвтрүүлэн ажиллаж байна.





## SCADA системийн давуу тал

- 24 цагийн тасралтгүй үйлдвэрлэл үйл ажиллагааг алсаас хянах, удирдах боломжтой ингэснээр хөдөлмөрийн зардал, цаг хугацаа хэмнэнэ.
- Дуу, дүрс бичигч камер, мэдрэгч тоног төхөөрөмжийн тусламжтайгаар объект, болон орчны аюулгүй байдал, эрсдэлийг тогтмол хянах боломжтой
- Усны үйлдвэрлэл үйл ажиллагааны тайлан мэдээллийг тогтмол харах, архивлах
- Алдааны төлөв байдлыг урьдчилан мэдэж, болзошгүй осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх, өндөр үнэ бүхий тоног төхөөрөмжийн эвдрэлийг багасгаж, ашиглалтын хугацааг уртасгах боломжтой болсон.
- Гэнэтийн осол гэмтэл гарсан тохиолдолд шуурхай мэдээлж яаралтай хариу арга хэмжээг шуурхай авах боломжтой юм.





ᠬᠥᠪᠰᠡᠭᠡᠯ ᠠᠶᠢᠮᠠᠭ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠡᠰᠡᠷ



# Азийн хөгжлийн банкны төслөөр шинээр тусгай зориулалтын автокрантай болж автобазаа өргөтгөв.





## 2024 ОНД ТАВЬЖ БУЙ ЗОРИЛТУУДААС...



- Шинэ техник, технологи, автоматжуулалт, шинэ санал санаачлага, туршлага нэвтрүүлэх
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар айл өрх, аж ахуй нэгж байгууллагыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, хэрэглэгчээ нэмэгдүүлэх
- Эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх (орлого, зардал, авлага)
- Цэвэр усны хэмнэлт, үнэ тарифийг нэмэгдүүлэх ажилчдын сахилга, хариуцлага, цаг ашиглалт, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг жигдрүүлэх
- Зардал нөхөх төлөвлөгөө мөрдөж, нягтлан бодох бүртгэлийг улам сайжруулж, аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах
- Инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтад хамруулж, хүний нөөцийг бэхжүүлэх
- Ажилчдын орон тоог нягтруулж, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх





## 2024 онд орон нутгийн төсөв болон өөрийн хөрөнгөөр хийгдэх томоохон ажлуудын ТОВЧОО:

- Нийт ус түгээх байруудын 70%-ийг 24 цагийн үйлчилгээтэй смарт худаг болгох
- Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон айл өрх, албан байгууллагуудын 20%-ийг ухаалаг тоолуураар **хангах**
- Ус түгээх байруудыг шинэчлэх, засварлах
- Цэвэр ус зөөврийн автомашинуудын парк шинэчлэл хийх
- Бие даасан халаалтын зуухнуудыг шинэчилж байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахаар ажиллах





# Хөвсгөл



## Мөрөн сум:

Цэвэр усны эх үүсвэр: 1500м<sup>3</sup>/хон

Шугамын урт:

- Цэвэр ус - 41,9км
- Бохир ус - 26,9км

Цэвэрлэх байгууламж: 3000м<sup>3</sup>/хон

## Инженерийн шугам сүлжээтэй сумд:

### Орон нутгийн өмчит:

Их-Уул  
Тариалан  
Цэцэрлэг  
Цагаан-Уул  
Түнэл  
Тосонцэнгэл  
Шинэ-Идэр

### Хувийн хэвшил:

Рашаант  
Төмөрбулаг  
Галт  
Жаргалант  
Бүрэнтогтох

Эрдэнэбулган сумын нэгдсэн дулаан хангамжийн ажил хийгдэж байна.

Цэцэрлэг сум 1600м урт бохир усны шугамтай, 75м<sup>3</sup>/хон цэвэрлэх байгууламжтай.

Их-Уул сум 500м бохир усны шугамтай, нэгдсэн бохир усны цооногтой.

Их-Уул, Цагаан-Уул, Цэцэрлэг, Тариалан, Шинэ-Идэр, Түнэл, Галт сумд цэвэр усны шугамтай.





# "Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил /Хөвсгөл, Мөрөн сум/"



**Тулгамдаж буй асуудал:** “Хөвсгөл Дулааны станц”ТӨХК-ийн өргөтгөлийн ажлыг хийлгэх шаарлагатай. Дулааны станцын өргөтгөл хийсний дараа дулаан хангамжид холбох техникийн нөхцөлтэй

**Хүчин чадал:** 1 дүгээр багт цэвэр, бохирын салбар шугамын ажил, 6 дугаар багт ДДТөв-2ш, дулаан хангамж, цэвэр, бохир усны шугамын засварын ажлын зургийн ажил

**Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч:** Санжат ХХК

**Зураг төслийн автор:** "Урбан девлопмент консалтинг групп" ХХК

**Захиалагчийн хяналтын байгууллага:** БХТ, Хөвсгөл ГХБХБГ

**Гэрээний дүн:** 22,672,412,857 төгрөг

**Ажлын явцын хувь:** 20%


**Гүйцэтгэгчийн холбоо барих утас:** 99110353

**Ажлын явц:** 1-р багт цэвэр бохирын салбар шугамын ажлын улаан шугам тавих ажил хийгдэж байна. 253 айл төвлөрсөн цэвэр бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломж бүрдэнэ. 6-р багийн 7,8-р гудамжны 55 айлын ажил хийгдсэн дулаан хангамж, цэвэр усны шугамын ажил хийгдсэн. нийт 500 айл төвлөрсөн дулаан хангамж, цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломж бүрдэнэ. Ажлын гүйцэтгэл 20 хувьтай явагдаж байна.





## Инженерийн шугам сүлжээ бүхий гэр хорооллын төсөл /Хөвсгөл, Мөрөн сум/



**Тулгамдаж буй асуудал:** “Хөвсгөл Дулааны станц” ТӨХК-ийн өргөтгөлийн ажлыг хийлгэх шаардлагатай. Дулааны станцын өргөтгөл хийсний дараа дулаан хангамжид холбох техникийн нөхцөлтэй

**Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч:**  
“Энерготех сервис” ХХК  
**Зураг төслийн автор:** “Монкузбасс” ХХК  
**Захиалагчийн хяналтын байгууллага:** БХТ,  
Хөвсгөл аймгийн ГХБХБГ  
**Гэрээний дүн:** 16,876,929,386 төгрөг  
**Ажлын явцын хувь:** 80%  
**Гүйцэтгэгчийн холбоо барих утас:** 88106199

**Ажлын явц:** 3, 4 дүгээр багт цэвэр, бохир усны шугамын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 494 айл төвлөрсөн цэвэр бохир усны шугамд холбогдох боломж бүрдэнэ. 13 дугаар багт дулаан, цэвэр усны шугамын угсралтын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Бохир усны шугамын ажил эхэлсэн. 1263 айл дулаан, цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд холбогдох боломж бүрдэнэ.




Инженерийн шугам сүлжээ бүхий гэр хорооллын төслийн ажил бүрэн хэрэгжсэнээр Мөрөн сумын нийт айл өрхийн 32%-нь төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох боломж бүрдэнэ.




ᠬᠥᠪᠰᠡᠭᠡᠯ ᠠᠶᠢᠮᠠᠭ  
ᠵᠢᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠠᠨ ᠲᠠᠮᠲᠤᠨ ᠭᠢᠰᠠᠷ

Одоо



■ Нийт айл өрх ■ Шугам сүлжээнд холбогдсон айл өрх

Цаашид



■ Нийт айл өрх ■ Төсөл хэрэгжиж дууссаны дараа





Хөвсгөл аймаг  
Мөрөн хот  
Хөвсгөл аймаг  
Мөрөн хот



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

*Хоймор нутгийн хөгжлийн төлөө*  
**ХАМТДАА**



Хөвсгөл аймаг Мөрөн хот



7038-1111



[www..khovsgol.gov.mn](http://www.khovsgol.gov.mn)

